# ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АГААРЫН ЗАМЫН БООМТ ХАРИУЦСАН ГАЗРААС 2020 ОНЫ НЭГДҮГЭЭР САРД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /2019.12.11 - 2020.01.31/

2020 оны 02 дугаар сарын 03 — Улаанбаатар хот

| Д/д | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин | Биелэлт | Хариуцах албан хаагч | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах чиглэлээр | Газрын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлэх. | Тайлан, төлөвлөгөөний биелэлт, хийх ажлын төлөвлөгөөнд тусгах саналыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд албан хаагчдаас авч, нэгтгэн Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна. | Захиргаа, Төв аймаг дахь төлөөлөл, боомтод ажиллаж буй 4 ээлжээс 2020 оны нэгдүгээр сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах саналыг авч нэгтгэн тус газрын даргаар батлуулж 2019.11.25-ны өдөр, харин хийсэн ажлын тайлан, төлөвлөгөөний биелэлтийг төвөөс тогтоосон хугацаанд авч нэгтгэн 2020.02.03-ны өдөр Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлэв. | Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Захиргааны ахлах мэргэжилтэн | 100 |
| 2 | | Байгууллагын инфографик мэдээнд тусгах статистик тоог гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах. | Тоон мэдээг 2019 онтой харьцуулан гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна. | Гадаадын иргэн, харьяатын газраас гаргадаг инфографик мэдээнд тусгах тус газрын 2020 оны 01 дүгээр сарын мэдээг 2019 оны мөн үетэй харьцуулж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст 2020.01.31-ний өдөр хүргүүлэв. Мэдээгээр 2019.12.11–2020.01.31-ний өдрийн байдлаар тус газарт ирсэн бичиг 23 үүнээс хариутай албан бичиг 13, явсан бичиг 18, ирсэн өргөдөл 0, гомдол 0 байгаа бол 2018.12.11-2019.01.25-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн бичиг 12 үүнээс хариутай албан бичиг 6, явсан бичиг 24, ирсэн | Захиргааны ахлах мэргэжилтэн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | өргөдөл 0, гомдол 0. Харин 2019.12.11 -2020.01.25-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн бичиг 19 үүнээс хариутай албан бичиг 10, явсан бичиг 16, ирсэн өргөдөл 0, гомдол 0 байна. | | |
| 3 | | Байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах. | Албан даалгаврын биелэлтийг үнэн зөв гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна. | Байгууллагын даргын батлан гаргасан 2017 оны 01, 03, 04, 05, 06, 07, 2018 оны 02, 04, 06, 08, 09, 10, 2019 оны 02, 03, 08, 2020 оны 01 дүгээр албан даалгаврын биелэлтийг гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст 2020.02.03-ны өдөр хүргүүлсэн. | Хяналтын улсын байцаагч | 100 |
| 4 | | Зохион байгуулалтын нэгжийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж төвд хүргүүлэх. | 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах саналыг албан хаагчдаас авч нэгтгэн холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | Зохион байгуулалтын нэгжийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж Захиргаа, удирдлагын газарт 2020.01.23-ны өдөр хүргүүлсэн бөгөөд Төсвийн шууд захирагч 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төсвийн төвлөрүүлэн захирагчтай 2020.01.24-ний өдөр байгуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | Захиргааны ахлах мэргэжилтэн | 100 |
| 5 | | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлтийг гаргаж төвд хүргүүлэх. | Биелэлтийг үнэн зөв, шалгуур үзүүлэлт тус бүрээр гаргаж Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний 2019 оны жилийн эцсийн тус газартай холбоотой арга хэмжээний биелэлтийг гаргаж 2019.12.24-ний өдөр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн. | Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн | 100 |
| 6 | Виз, бүртгэлийн чиглэлээр | Гадаадын иргэнд виз олгох, визний шилжүүлэг хийх, бүртгэл, хасалтын үйлчилгээ үзүүлэх. | Төрийн үйлчилгээг гадаадын иргэнд түргэн шуурхай үзүүлсэн байна. | Нийт 67 орны 324 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс визийн шилжүүлэг 10. Үүнд нэг удаагийн орох230, хоёр удаагийн орох 1, олон удаагийн орох 7, нэг удаагийн гарах- | Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | орох 51, хоёр удаагийн гарах-орох 1, олон удаагийн гарах-орох 16, дамжин өнгөрөх 2, түр ирэгчийн бүртгэл 88, хасалт 103, оршин суух зөвшөөрлийн хасалт 118 байна. Дипломат төлөөлөгчийн газраас алдаатай олгосон 4 орны 11 гадаадын иргэний визийг хүчингүй болгож шинээр олгож, оршин суух зөвшөөрөлийн хасалтыг төвд хийлгэсэн 2 орны 4 гадаадын иргэний олон удаагийн визийг хүчингүй болгов. Монгол Улсад 180 хоногоос дээш хугацаагаар зорчсон, хөрөнгийн эх үүсвэргүй 3 орны 17 гадаадын иргэний визийг хүчингүй болгон буцаав | Хяналтын улсын байцаагч нар | |
| 7 | | Монгол Улсын визгүй, хориг арга хэмжээ авагдсан гадаадын иргэнийг буцаах арга хэмжээ авч ажиллах. | Гадаадын иргэний мэдээллийг “ISM” систем дээр шалгаж визгүй, хориг арга хэмжээтэй гадаадын иргэнийг хил нэвтрүүлэлгүй буцаасан байна. | Монгол Улсаас албадан гаргагдаж орохыг хориглосон хугацаа нь дуусаагүй байсан 1 орны 2 гадаадын иргэн, орох визгүй 1 орны 1 гадаадын иргэнийг тус тус улсын хилээр оруулаагүй буцаасан байна. Харин гарах-орох визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр 11 орны 21 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргаагүй болно. Шүүх, ШШГЕГ-ын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна. | Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч нар | 100 |
| 8 | Хяналт шалгалтын чиглэлээр | Тус газрын хяналт шалгалтын 2020 оны төлөвлөгөөг нэгтгэн гаргаж батлуулахаар төвд хүргүүлэх. | Хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар Гадаадын иргэн, харьяатын газарт хүргүүлсэн байна. | Тус газраас явуулах хяналт шалгалтын 2020 оны төлөвлөгөөг боловсруулж 2020.01.02–ны өдөр төвд хүргүүлэн байгууллагын даргаар батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | Хяналтын улсын байцаагч | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 9 | | Төв аймаг дахь Цагдаагийн газартай 2019 онд хамтран ажиллах төлөвлөгөөний биелэлтийг гаргах. | Биелэлтийг үнэн зөв, шалгуур үзүүлэлт тус бүрээр гаргаж тус газрын даргад танилцуулсан байна. | Төв аймаг дахь Цагдаагийн газартай 2019 онд хамтран ажиллах төлөвлөгөөний биелэлтийг гаргаж 2019.12.15-ны хүргүүлсэн. Нийт 12 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд биелэлт 90 хувьтай гарсан. | Төв аймаг дахь ахлах мэргэжилтэн | 90 |
| 10 | | Төв аймаг дахь Цагдаагийн газартай 2020 онд хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулж батлуулах. | Цагдаагийн байгууллагаас санал авч нэгтгэн батлуулсан байна. | Төв аймаг дахь Цагдаагийн газартай 2020 онд хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулж 2020.01.05-ны өдөр батлуулан үйл ажиллагаан-даа мөрдөн ажиллаж байна. | | 100 |
| 11 | | Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ААН-д хяналт шалгалт хийх | Удирдамж батлуулан хяналт шалгалтыг зохион байгуулж, дүнг тус газрын даргад танилцуулсан байна. | Тус газрын даргын 2019.12.18-ны өдрийн 10/01 дугаар удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Төв аймгийн Аргалант, Заамар сумын нутаг дэвсгэрт нохой үржүүлгийн газарт шалгалт хийсэн. Шалгалтаар 1 орны 2 гадаадын иргэнийг шалгахад зөрчил илрээгүй.<br>Тус газрын даргын 2020.01.27-ны өдрийн 2020-10/02 дугаартай удирдамжийн дагуу Төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй 4 аж ахуй нэгж, байгууллагад хяналт шалгалт явуулсан. Шалгалтаар 1 орны 2 гадаадын иргэн хамрагдсан бөгөөд зөрчил илрээгүй. | Хяналтын улсын байцаагч нар | 100 |
| 12 | | Зөрчлийн тухай хуулийн дагуу ГИЭЗБТХууль зөрчсөн гадаадын иргэн, ААН-ийн зөрчлийг арилгаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах. | Зөрчил гаргасан гадаадын иргэн, ААН, байгууллагын зөрчлийг шийдвэрлэж, зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. | Бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух журам зөрчсөн зэрэг үндэслэлээр 10 орны 41 гадаадын иргэнд 9,040,000 төгрөг, 16 аж ахуйн нэгжид /хамрагдсан 24 гадаадын | Хяналтын улсын ахлах байцаагч, Хяналтын улсын байцаагч нар | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | иргэн/ 5,420,000 төгрөг, нийт 14,460,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгөв. | | |
| 13 | | Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг илрүүлсэн тохиолдолд Монгол Улсаас албадан гаргах үйл ажиллагааг зохион байгуулах. | Холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хийсэн байна. | Визийн хугацаа хэтрүүлсэн, виз, бүртгэлийн журмыг 1 жилд 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн 3 орны 3 гадаадын иргэнийг тус улсаас албадан гаргаж мэдээллийн санд бүртгүүлсэн болно. Төвөөс 6 орны 16 гадаадын иргэнийг албадан гаргаж буй үйл ажиллагаанд албан хаагчид оролцож, тодорхойлолт үйлдэв. | Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч нар | 100 |
| 14 | | Визгүй зорчдог болон хоригт багтсан орны иргэдэд хил дээр тавих хяналтыг сайжруулж ажиллах. | Хил дээр тавих хяналт сайжирсан байна. | Монгол Улсад визгүй зорчигч гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 14 орны 69 гадаадын иргэнтэй ярилцлага хийж бичиг баримтыг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөлсөн. Иргэд харилцан зорчих нөхцлийн талаар байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсад зорчин ирж буй 5 орны 14 гадаадын иргэнийг угтан авч буй уригч 5 иргэнээр баталгааны анкет бөглүүлэн хил нэвтрүүлж, уг гадаадын иргэний гарах хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна. | Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нар | 100 |
| 15 | Хүний нөөц, сургалтын чиглэлээр | Төрийн албаны зөвлөлийн цахим санд албан хаагчдын мэдээллийг шивж оруулан баяжилт хийх | Тус газарт албан хаагчдын мэдээллийг нэг бүрчлэн шивж оруулсан байна. | Төрийн албаны зөвлөлийн цахим програмд төрийн албан хаагчдын 2020.01.01-ний өдрөөс шинэчилсэн цалингийн сүлжээг 2020.01.03-ны өдөр, албан хаагчдын 2019 оны гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээг | Захиргааны ахлах мэргэжилтэн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2020.01.30-ны өдөр, нэмэгдэл, шагнал зэрэг мэдээллийг 2020.01.31-ний өдөр шивж оруулсан. | | |
| 16 | | Тус газраас 2019 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж төвд хүргүүлэх. | Биелэлтийг үнэн зөв, шалгуур үзүүлэлт тус бүрээр гаргаж Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна. | Агаарын замын боомт хариуцсан газраас 2019 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний биелэлтийг 2019.12.11-ний өдөр гаргаж Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу нийт 21 төрлөөс сургалт зохион байгуулахаар тусгасан бөгөөд биелэлт 100 хувьтай гарсан. Гадаад сургалтанд 4 албан хаагч, дотоодын 45 сургалтанд давхардсан тоогоор 528 албан хаагч хамрагдсан. | Захиргааны ахлах мэргэжилтэн | 100 |
| 17 | | Тус газраас 2020 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулах | Байгууллагын сургалтын хөтөлбөртэй уялдуулан гаргасан байна. | АЗБХГ-аас 2020 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг боловсруулахдаа албан хаагчдаас санал авч, байгууллагын сургалтын хөтөлбөр болон 2020 оны сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан 2020.01.10-ны өдөр батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | | 100 |
| 18 | | Тус газраас 2019 онд албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний биелэлтийг гаргаж төвд хүргүүлэх. | Биелэлтийг үнэн зөв, шалгуур үзүүлэлт тус бүрээр гаргаж Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна. | ГИХГ-ын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх АЗБХГ-ын 2019 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж 2019.12.11-ний өдөр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу 18 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд биелэлт 100 хувьтай гарсан. | | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 19 | | Тус газраас албан хаагчдын нийгмийн баталгааг 2020 онд хангах төлөвлөгөөг боловсруулж батлуулах | Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөртэй уялдуулан гаргасан байна. | АЗБХГ-ын албан хаагчдын нийгмийн баталгааг 2020 онд хангах төлөвлөгөөг боловсруулахдаа албан хаагчдаас санал авч, байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, ГИХГ-ын 2020 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөтэй уялдуулан 2020.01.10-ны өдөр батлуулсан. | Захиргааны ахлах мэргэжилтэн | 100 |
| 20 | | Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох ажлыг зохион байгуулах. | Төрийн үйлчилгээний албан хаагчдын хийсэн ажлыг нэгтгэн гаргаж ур чадварын нэмэгдэл олгуулах саналыг газрын даргад танилцуулж тушаал гаргасан байна. | Тус газрын төрийн үйлчилгээний 5 албан хаагчийн ажлыг дүгнэж 2019 оны 12 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг 2019.12.20-ны өдөр Б/19, 2020 оны 01 дүгээр сарын ур чадварын нэмэгдлийг 2020.01.23-ны өдөр Б/03 дугаар тушаалын дагуу олгов. | | 100 |
| 21 | Санхүү, хангамжийн чиглэлээр | Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өр авлагагүй ажиллах. | Төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэн ажилласан байна. | Батлагдсан төсөв болох 52,153,800 төгрөгийн санхүүжилт орсноор цалин хөлсөнд 34,865,158 төгрөг, ажил олгогч болон даатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэл 8,336,465.30 төгрөг, Хан-Уул дүүрэгт цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 2,519,669 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажиллалаа. | Ахлах нягтлан бодогч, Нярав | 100 |
| 22 | | Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв гарган тогтоосон хугацаанд тайлагнах. | НД-ын шимтгэлийн тайланг дараа сарын 5, төсвийн гүйцэтгэлийн тайланг дараа сарын 2-ны өдрийн дотор гаргаж төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоо бүрдсэн байна. | Нийгмийн даатгалын шимтгэлийн 2019 оны тайланг гарган 2020.01.05-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн өссөн дүнгээр 96,755,5888.79 төгрөгөөр тооцоо нийлэв. Төсвийн гүйцэтгэлийн 2019 оны мэдээг 2020.01.02-ны өдрийн дотор гарган Хан-Уул дүүргийн Төрийн | | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | сангаар баталгаажуулан Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн. Мэдээгээр 559,883,800 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 558,138,885.01 төгрөгийн ажил үйлчилгээ явуулсан. | Ахлах нягтлан бодогч, Нярав | |
| 23 | | Үнэт цаасны тооцоо, авто машин ашиглалтын болон шатах тослох материалын тооцоог хугацаанд нь гаргаж, бүртгэл хөтлөн ажиллах. | Бүртгэл тооцоо хугацаандаа чанартай хийгдсэн байна. | Албан хаагчдад шийтгэлийн хуудас 0, визийн хуудас ширхэгийг олгосон бөгөөд Баруун бүс дэх газарт 191 ширхэг визийн хуудас 2020.01.22-ны өдөр шилжүүлсэн. Түүнчлэн авто машины ашиглалт болон шатах тослох материалын тооцоог жолооч дэвтэрт бичилтийг хийн бүртгэл хөтлөв. | | 100 |
| 24 | | Төсвийн хүрээнд худалдан авалт хийх, албан хаагчдын ажиллах нөхцлөөр хангаж ажиллах. | Шаардлагатай бараа материалын худалдан авалт хийж шаардах хуудасны дагуу бараа материалыг тухай бүр нь гаргаж өгсөн байна. | Бараа материалд 214,000 төгрөгийн худалдан авалтыг хийж шаардах хуудасны дагуу албан хаагчдад өгсөн. Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан. Түлш шатах тослох материалд ажил үйлчилгээ хийгдээгүй. | | 100 |
| 25 | | Албан хэрэгцээнд ашиглаж буй суурин утас, шуудангийн болон боомтод байрлах албан хаагчдын ажлын байрны түрээсийн төлбөр тооцоог нэхэмжлэхийн дагуу тухай бүр шийдвэрлэх. | Нэхэмжлэхийн дагуу тухайн байгууллагын холбогдох дансруу шилжүүлэн өглөг авлагагүй ажиллана. | Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт 20,382 төгрөг, байрны түрээс 3,085,750 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс уруу шилжүүлсэн болно. | | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 26 | | Татварын улсын тэмдэгтийн хураамж, хүү, торгуулийн тайланг гаргаж тооцоо нийлэх. | Хяналтын улсын байцаагч нараас тайланг авч тулган, сар бүрийн 5-ны дотор төвд хүргүүлсэн байх. | Хүү торгууль 14,460,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж 29,183,100 төгрөгөөр тайлан нэгтгэн хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн. | Ахлах нягтлан бодогч, Нярав | 100 |
| 27 | | Бараа материалын тайлан, кассын тайланг тухай бүр гаргах. | Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн ажилласан байна. | Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан. | | 100 |
| 28 | | Газрын албан хаагчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийх. | Албан хаагчдын НДД, ЭМД-ын дэвтэрт бичилт хийж нийгмийн даатгалын байцаагчаар НДД-ийг баталгаажуулсан байна. | Тус газрын 28 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагчийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав. | | 100 |
| 29 | | Газрын 2019 оны санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж төвд хүргүүлэх. | Тайланг үнэн зөв гаргаж төвийг мэдээллээр хангаж ажилласан байна. | АЗБХГ-ын 2019 оны санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж төвд 2020.01.16-ны өдөр 10/05 дугаартай албан бичгээр хүргүүлсэн болно. | | 100 |
| 30 | | Нийгмийн даатгал, татварын тайланг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх | ХУД-ийн НДХ, Татварын хэлтэст хүргүүлсэн байна. | Тус газар нийгмийн даатгал, татварын тайланг гаргаж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Татварын хэлтэст хүргүүлсэн болно. | | 100 |
| 31 | | Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэх | Тооцоо нийлж баталгаажуулсан байна. | Тус газар “БООШ”, “Магнай Трейд” “Юнивишн”, “Чингис хаан” олон улсын нисэх буудал, Төв аймгийн Төрийн сан, ГИХГ-ын Санхүү, хангалт үйлчилгээний газар, ГИХГ-ын | | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дорноговь аймаг дахь газар, ИНЕГ, “Номт марал”, “Голден шийл груп” ХХК, Хан-Уул Дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, “Бапана трейд” ХХК-тай тооцоо нийлж баталгаажуулсан болно. | | |
| 32 | Өргөдөл, гомдлын чиглэлээр | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл, гомдол гаргах бүрт бүртгэл хөтлөн, холбогдох албан хаагчид хүргүүлж, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлэх. | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлсэн байна. | Агаарын замын боомт хариуцсан газарт ирсэн өргөдөл, гомдлыг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, уг өргөдөл, гомдолд “Бүртгэл-хяналтын карт” хөтөлж, газрын даргад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хүргүүлэн ажилладаг болно.<br>Энэ сард иргэн, ах ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас ирсэн өргөдөл, гомдол байхгүй бөгөөд мэдээг 2020.01.31-ний өдөр Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлэв. | Захиргааны ахлах мэргэжилтэн | 100 |
| 33 | Бичиг хэрэг, архивын үйл ажиллагааны чиглэлээр | Газарт ирсэн, явсан албан бичгийн бүртгэл хөтөлж, хариутай албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах. | Ирсэн, явсан бичгийн бүртгэлийг хөтөлжсөн хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна. | Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу тус газарт ирсэн нийт 21 албан бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, хариутай 11 албан бичигт “Бүртгэл-хяналтын карт” хөтлөн, газрын даргад танилцуулан цохолт хийлгэж, холбогдох албан хаагчид шилжүүлэн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллав. Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн талаар “Бүртгэл-хяналтын карт”-д тэмдэглэв. Тус газраас 18 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв. | | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 34 | | Тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэх. | Ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэсэн байна. | Цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд ирсэн 21, явсан 18 албан бичиг, тус газрын даргын батлан гаргасан 12 тушаал, сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг скайнердаж цахим хэлбэрт шилжүүлэв. | Захиргааны ахлах мэргэжилтэн | 100 |
| 35 | | Хэвлэмэл хуудасны зарцуулалтын бүртгэлийг хөтлөн тус газрын даргад танилцуулах. | Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолын хэрэгжилт хангагдсан байна. | Агаарын замын боомт хариуцсан газрын өдөр тутмын үйл ажиллагаанд ашигладаг хэвлэмэл хуудасны зарцуулалтын тайланг гаргаж тус газрын даргад танилцуулж ажиллалаа. Албан бичгийн А4, А5, тодорхойлолтын А5 хэвлэмэл хуудас, тус газрын даргын тушаалын хэвлэмэл хуудасны 2019.12.01-2019.12.31-ний өдрийн зарцуулалтын тайланг 2020.01.09-ний өдөр болон 2020.01.01-2020.01.31-ний өдрийн зарцуулалтын тайланг 2020.02.03-ны өдөр гаргаж тус газрын даргад танилцуулав. | | 100 |
| 36 | | 2020 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалт гаргах. | Тус газрын ББНШК-ын хурлаар хэлэлцэж хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлан гаргасан байна. | Төвөөс тус газрын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтанд өөрчлөлт ороогүй тул 2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн гаргах шаардлагагүй гэсэн чиглэл өгсөн. | | 0 |
| 37 | | Тус газраас архив, албан хэрэг хөтлөлтийн талаар 2019 онд хийх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргах. | Биелэлтийг үнэн зөв, шалгуур үзүүлэлт тус бүрээр гаргаж тус газрын даргад танилцуулсан байна. | ГИХГ-ын Агаарын замын боомт хариуцсан газраас архив, албан хэрэг хөтлөлтийн талаар 2019 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж 2019.12.11-ний өдөр тус газрын даргад танилцуулсан. Нийт 21 төрлийн арга хэмжээний биелэлт 100 хувьтай гарсан. | | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 38 | | Тус газраас архив, албан хэрэг хөтлөлтийн талаар 2020 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулах. | Төлөвлөгөөг боловсруулж тус газрын даргаар батлуулсан байна. | Гадаадын иргэн, харьяатын газрын Агаарын замын боомт хариуцсан газраас архив, албан хэрэг хөтлөлтийн талаар 2020 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 2020.01.06-ны өдөр тус газрын даргаар батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | Захиргааны ахлах мэргэжилтэн | 100 |
| 39 | | Тус газарт 2019 онд үүссэн баримтын архивт хүлээн авах хувиар батлан гаргах | Хувиарыг батлан гаргаж албан хаагчдад танилцуулсан байна. | 2019 онд үүссэн архивын нэгжийг хүлээн авах хувиарийг 2020.01.15-ны өдөр батлан гаргасан бөгөөд өнөөдрийн байдлаар 1 архивын нэгж хүлээн авсан. | | 100 |
| 40 | | Архивын өрөөний чийг, дулааныг хэмжиж бүртгэл хөтлөх. | Хэмжилтийг өдөр бүр хийж, бүртгэл хөтөлсөн байна. | Тус газрын архивын өрөөний чийг, дулааныг ажлын өдрүүдэд өдөр бүр хэмжиж дэвтэрх бичилт хийн ажиллав. Дулаан 20-25С, чийг 20-30RH байна. | | 100 |
| 41 | Мэдээллийн технологийн чиглэлээр | Сүлжээний тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллах. | Ирсэн дуудлагын дагуу засвар үйлчилгээг хийж хэвийн ажиллагаанд оруулсан байна. | Сүлжээ болон техник хэрэгслийн өдөр тутмын хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан бөгөөд нийт 9 дуудлага хүлээн авч засварлаж ажиллалаа. Дотоод сүлжээ энэ хугацаанд хэвийн ажилласан ба шинэчлэлийг дотоод сүлжээний компьютерт суулгасан. Тус газрын нийт 11 компьютерийн хэвийн ажиллагааг шалгасан. Төвд 2020.01.13 –2020.01.31-ний өдрийг дуустал дадлагажин ажилласан. Тус хугацаанд төв газрын 2 давхарт байрлах киоск төхөөрөмжид байгууллагын танилцуулга харуулах ажлыг хийж, байгууллагын веб сайтад хөгжүүлэлт хийв. | Сүлжээний инженер | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 42 | Олон нийттэй харилцах чиглэлээр | Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг тухай бүр оруулж, иргэд хүссэн мэдээллээ авах боломжийг бүрдүүлэх. | Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж, мэдээг үнэн зөв оруулсан байна. | Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг шивж оруулсан. Тухайлбал, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл зэрэг болно. | Ахлах нягтлан бодогч | 100 |
| 43 | | Тус газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах. | Тус газрын сарын төлөвлөгөө, биелэлт, тайлан, өргөдөл, гомдлын мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна. | Тус газрын мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудсанд 2019 оны 12 дугаар сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, зохион байгуулсан сургалтын талаарх мэдээ, тайлан, өргөдөл, гомдлын мэдээ, 2020 оны 01 дүгээр сард хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллалаа. | Захиргааны ахлах мэргэжилтэн, Сүлжээний инженер | 100 |

Төлөвлөсөн: 43
Биелсэн: 42
Хагас биелсэн: 0
Биелээгүй: 1
Хувь: 98